


Гантиг

Гантиг чулуу олборлох үйлдвэр орд газраасаа $a \times b \times c$ метр хэмжээтэй, тэгш өнцөгт параллелограм хэлбэртэй цул гантигийг гарган авч зүсэх цех рүү илгээжээ. Энд a, b, c нь бүхэл тоонууд ($1 \leq a, b, c < 10^6$).

Цехэд авчирсан цул гантигийг хөрөөний тусламжтайгаар $1 \times 1 \times 1$ метр хэмжээтэй кубуудад хувааж зүсэх ёстой.

Гантигийг зүсэхийн тулд эхлээд түүнийг хөрөөний доор тискинд хавчуулан байрлуулна. Хөрөөний ир нь зүсэх гэж байгаа гадаргуунуудтайгаа перпендикуляр, бусад талуудтай параллелаар байрлана.



Тискинд нэг зэрэг хэд хэдэн гантигны хэсгийг хавчуулан хөрөөдөх боломжгүй ба зөвхөн нэг л гантигны хэсгийг хавчуулан хөрөөдөж болно.

Өгөгдсөн цул гантигийг нэгж хэмжээтэй кубуудад хуваахын тулд хөрөөг хамгийн багадаа хэдэн удаа ажиллуулах хэрэгтэйг тодорхойл.

Input

a, b, c бүхэл тоонууд хоосон зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

Output

Хөрөөг хамгийн багадаа хэдэн удаа ажиллуулахыг илэрхийлсэн нэг бүхэл тоог гаргана.

Example

Input:

5 3 4

Output:

59